

БУЛГАН АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2020 ОНЫ 10 ДУГААР САРЫН МЭДЭЭ

Нэг. Удирдлага зохион байгуулалтын талаар:

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны талаар:

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлыг хоёр удаа хийж, 3 асуудал хэлэлцэн, 3 тогтоол гаргалаа. Хурлаар Аймгийн сонгуулийн хорооны гишүүний тухай, Ардын хатанбаатар С.Магсаржавын нэрэмжит шагнал олгох тухай асуудал хэлэлцлээ. Ардын хатанбаатар С.Магсаржавын нэрэмжит шагналыг “Жигүүр гранд” группийн Ерөнхийлөгч Д.Баттөр олгожээ.

Мөн аймгийн ИТХ-ын найм дахь удаагийн сонгуулийн анхдугаар хуралдааныг Булган суманд хуралдуулахаар шийдвэрлэлээ.

Булган аймгийн ИТХ-ын найм дахь удаагийн сонгуулийн анхдугаар хуралдаан 2020 оны 10 дугаар сарын 30-ны өдөр болж, аймгийн ИТХ-ын төлөөлөгчийн бүрэн эрхийн тухай, аймгийн ИТХ-ын даргыг сонгох тухай, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийг сонгох тухай, аймгийн Засаг даргад нэр дэвшүүлэх тухай асуудал хэлэлцлээ. Аймгийн ИТХ-ын 33 төлөөлөгчийн бүхэн эрхийг зөвшөөрч, аймгийн ИТХ-ын даргаар Д.Эрдэнэбатыг сонголоо. Аймгийн Засаг даргаар Б.Ариун-Эрдэнийг томилуулахаар Монгол Улсын Ерөнхий сайдад санал болголоо. Мөн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийг 11 хүний бүрэлдэхүүнтэй сонгож батлав.

Төрийн захиргааны чиглэлээр:

Орхон, Хангал, Сэлэнгэ, Тэшиг сумдын Эрүүл мэндийн төвийн даргын сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, 4 иргэн оролцсоноос эцсийн 3 иргэн тэнцсэн. Сонгон шалгаруулалтын дүнг Төрийн албаны зөвлөлийн Булган аймаг дахь салбар зөвлөлийн хурлаар хэлэлцэн баталгаажуулж Хангал, Сэлэнгэ, Тэшиг сумын Эрүүл мэндийн төвийн даргын албан тушаалд сонгон шалгаруулалтад тэнцсэн иргэдийг томилуулахаар нэр дэвшүүлээд байна.

Мэргэжлийн хяналтын газрын Эрүүл мэнд, боловсрол, хүнсний хяналтын хэлтсийн дарга бөгөөд улсын ахлах байцаагч, Санхүүгийн хяналт, аудитын албаны Дотоод аудитор, санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчийн албан тушаалын сул орон тоог нөхөх тусгай шалгалтыг зохион байгуулж тус бүр 1 нийт 2 албан хаагч оролцлоо. Тусгай шалгалтын дүнг Төрийн албаны зөвлөлийн Булган аймаг дахь салбар зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн баталж, дээрх 2 иргэнийг өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар нэр дэвшүүлэн, томилгоонд хяналт тавьж ажиллалаа.

Онцгой байдлын чиглэлээр:

Монгол Улсын Шадар сайдын ажлын алба, Улсын Онцгой комиссын Шуурхай штаб, Эрүүл мэндийн яам, ХӨСҮТ, Дэлхийн Эрүүл мэндийн байгууллагын хамтарсан ажлын хэсгээс тус аймгийн Онцгой комиссын дэргэдэх Шуурхай штаб, шуурхай хариу арга хэмжээ авах багийг бэлтгэх, чадавхижуулах, сургаж дадлагажуулах сургалтыг 2020 оны 10 дугаар сарын 2-3-ны өдрүүдэд зохион байгуулж, сургалтанд тус аймгийн холбогдох гамшгаас хамгаалах алба,

мэргэжлийн анги, байгууллага, аж ахуйн нэгжээс албан тушаалтан, ажилчид оролцож аймгийн Засаг даргын захирамжаар шуурхай штаб, шуурхай багийг томилгоожуулан ажиллаа.

Аймгийн Засаг даргын 2020 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн “Гамшгаас хамгаалах сургууль, бэлэн байдлын үзлэг явуулах тухай” А/382 тоот захирамжын дагуу Бүрэгхангай суманд “Болзошгүй гамшгийн үед нутгийн удирдлагын үйл ажиллагаа” сэдвээр иж бүрэн сургууль, Могод суманд “Гамшиг ослын үед сумын гамшгаас хамгаалах штаб, алба, мэргэжлийн ангийн бэлэн байдал” сэдвээр бэлэн байдлын үзлэгийг зохион байгууллаа. Тус сургууль, үзлэгийг аймгийн Гамшгаас хамгаалах Эрүүл мэнд, Хүнс, хөдөө аж ахуй, Мэргэжлийн хяналтын албатай хамтран удирдлага зохион байгуулалтаар ханган мэргэжлийн анги, бүлгийн хамтарсан аврах ажиллагааны дадлага сургууль, хээрийн хүн, мал эмнэлгийг дэлгэн ажиллах үзүүлэх сургууль, гамшгаас хамгаалах удирдлага штаб, Онцгой комиссын гишүүдийн цагийн байдлыг үнэлж шийдвэр гаргах ажиллагаа зэрэг дадлага сургуулийг зохион байгуулж үнэлж дүгнэлээ.

Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2020 онд аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн баталсан төлөвлөгөөний дагуу Бүрэгхангай, Сэлэнгэ, Хангал, Хялганат, Орхон, Баяннуур, Дашинчилэн, Могод сумын Засаг даргын Тамгын газраас зохион байгуулж байгаа ажил, алба, мэргэжлийн анги, гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсэг, байгууллага, аж ахуйн нэгжийн бэлэн байдлыг тодотгон, гарсан зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээг зохион байгуулж ажилласан.

Булган аймгийн Булган сум, Хангал сум, Хялганат тосгонд “Гамшгийн эрсдэлийг бууруулах олон улсын өдөр”-ийг тохиолдуулан Нээлттэй хаалганы өдрийг 2020 оны 10 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулж 96 хүнийг хамруулсан байна.

Булган аймгийн Бүрэгхангай, Дашинчилэн, Баяннуур, Рашаант, Гурванбулаг, Могод, Сайхан, Орхон сумдын нутаг дэвсгэрт тэсэрч дэлбэрэх бодисын агуулах, химийн хорт бодис ашиглан үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээдийн барилга байгууламжид хяналт шалгалт хийх хамтарсан удирдамжийн дагуу Онцгой байдлын газар, Цагдаа, Мэргэжлийн хяналтын байгууллагын хамтарсан ажлын хэсэг 16 байгууллагад хяналт шалгалтыг зохион байгуулж, заавар зөвлөмжийг өгч ажилласан.

Гарсан гамшиг, аюулт үзэгдэл, ослын талаар

2020 оны 10 дугаар сарын байдлаар аймгийн хэмжээнд объектын гал түймэр 1 удаа, ой, хээрийн гал түймрийн мэдээ 1 удаа, хүн алга болсон эрлийн дуудлага 1 удаа, галзуу өвчний дуудлага 1 удаа ирсэн байна. Гал түймрийн улмаас өвөл, зуны байшин 1 өртөж, /гал түймрийн хохирол бүрэн гараагүй байна.

Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд:

2020 оны эхний 10 сарын байдлаар өссөн дүнгээр улсын төвлөрсөн төсөвт 658,300,0 мянган төгрөг төвлөрүүлэх төлөвлөгөөтэйгөөс 741,336.0 мянган төгрөгийг төвлөрүүлж орлогын төлөвлөгөөг 112.6%, аймгийн төсөвт 15,779,900.0 мянган төгрөгийг төвлөрүүлэхээс 15,565,135.0 мянган төгрөгийг төвлөрүүлж

орлогын төлөвлөгөөг 98,6%, сумын төсөвт 1,507,887.0 мянган төгрөгийг төвлөрүүлэхээс 2,197,051.0 мянган төгрөгийг төвлөрүүлж төлөвлөгөөг 145,7% хувь, нийт улс, аймаг, орон нутгийн төсөвт 17,946,087,0 мянган төгрөг төвлөрүүлэх төлөвлөгөөтэйгөөс 18,503,522,0 мянган төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 103.1 хувиар биелүүлэн ажиллалаа.

Тайлант сард өмнөх оны нийт 1,890,693.1 мянган төгрөгийн татварын өрөөс 9,724.0 мянган төгрөгийг, тайлан оны нийт 1,105,954.2 мянган төгрөгийн өрөөс 191,205.3 мянган төгрөгийг тус тус барагдуулаад байна.

9 сарын нэмэгдсэн өртгийн албан татварын тайланг 201 татвар төлөгч ирүүлэхээс 199 татвар төлөгч ирүүлж тайланг 99 хувийн ирцтэйгээр хүлээн авлаа.

Шинээр улсын бүртгэлд бүртгүүлсэн 12 хуулийн этгээдийг татвар төлөгчийн бүртгэлд, 3 хуулийн этгээдийн хасалтын бүртгэл, 3 татвар төлөгчийн бүртгэлийн өөрчлөлт, шинээр татвар төлөгчийн бүртгэлд 18 иргэнийг шинээр татвар төлөгчийн бүртгэлд тус тус бүртгэн холбогдох ногдлыг үүсгэж ажиллалаа.

СХААлба нь Газрын харилцаа барилга хот байгуулалтын 2018-2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт шалгалт хийсэн. Өмнөх оны актын төлбөрийн үлдэгдлийг шийдвэрлүүлэхээр хууль хяналт байгууллагад шилжүүлэв.

Багийн эмнэлгийн барилгын өргөтгөл /Хутаг-Өндөр сум, Уньт баг/-ийн ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулах тендерийг харьцуулалтын аргаар 2 удаа зарлаж “Хурмастын хүлэг” ХХК-ийг сонгон шалгаруулж гэрээ байгуулан ажил эхэлсэн.

Булган аймгийн Нэгдсэн эмнэлэгт Дижитал суурин рентген аппарат нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийг нээсэн үнэлгээ хийгдэж байна

Гурав: Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:

Хууль зүйн сайдын эрхлэх хүрээний агентлагууд болон аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх, зүйн хэлтсээс 2020 оны 10 дугаар сард дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Харуул хамгаалалтын 110 албан хаагчид бие хамгаалах болон бусад гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар сургалт зохион байгуулж, 30 ширхэг гарын авлага материалыг бэлтгэж тараасан.

Нутгийн захиргааны байгууллагад эрх зүйн туслалцаа үзүүлэх ажлын хүрээнд 10 дугаар сард 2 сумын Засаг даргын 82 захирамж, 35 тушаалын эрх зүйн үндэслэлийг хянаж, зөвлөмж чиглэл хүргүүлэн ажиллалаа.

Гурванбулаг сумын цагдаагийн хэсэгт хяналт шалгалт хийхэд 1 500 000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.

Иргэдийн хууль ёсны эрхийг хамгаалах, хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэх зорилтын хүрээнд аймгийн Хууль зүйн туслалцааны төвөөр 13 иргэн үйлчлүүлж хуулийн зөвлөгөө, өмгөөллийн үйлчилгээг авсан байна.

Аймгийн хэмжээнд 2020 оны 10 дугаар сард бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлыг танилцуулахад 313 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 105 хэргээр буюу 25.2 хувиар буурсан. Илрүүлэлтийн хувь 46.4 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 2.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Сайхан, Сэлэнгэ, Хялганат, Бүрэгхангай, Хангал, сумдад урьд

оны мөн үеэс өсч, Гурванбулаг, Баяннуур, Орхон, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр, Тэшиг, Бугат, Дашинчилэн, Рашаант Баян-Агт, Булган сумдад урьд оны мөн үеэс буурсан байна. Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн тухайд 64 бүртгэгдэж 11 хэргээр буюу 17.2 хувиар өссөн үзүүлэлттэй.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажлын чиглэлээр 10 дугаар сард хорихоос өөр төрлийн ял шийтгэл эдэлсэн иргэдээс торгох ялын 26 гүйцэтгэх хуудасны 88 727 000 төгрөгийн үлдэгдэлтэй, нийтэд тустай ажил хийлгэх ялын 4 гүйцэтгэх хуудасны 880 цагийн үлдэгдэлтэй, эрх хасах ялын 14 гүйцэтгэх хуудасны 6395 хоногийн үлдэгдэлтэй байна. Албадлагын арга хэмжээ авсан тэнссэн 56 иргэн, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авсан 2, хөрөнгө орлого хураах 27 гүйцэтгэх хуудасны үлдэгдэл 108 697 600 төгрөг, шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан 1, хугацаанаас өмнө тэнсэн суллагдсан 19, зөрчлийн

Шүүх шинжилгээний албан чиглэлээр нийт 29 хэргийн газрын үзлэгт мэргэжилтнээр оролцож хулгайн 9, зам тээврийн ослын 7, хүний амь нас хохирсон 9, бусад 4 хэргийн газрын үзлэгт оролцон 961 кадр гэрэл зургаар 29 ул мөр бэхжүүлсэн. Илрүүлсэн гарын мөр 8, гутлын мөр 3, тээврийн хэрэгслийн мөр 13, эвдлэгч багаж 1, биологийн гаралтай ул мөр 4 бусад ул мөр 1 илрүүлж нийт 30 ул мөр бэхжүүлж ажилласан байна. Шүүх эмнэлгийн 84 шинжилгээ хийсэн. Үүнээс хүний биед гэмтлийн зэрэг тогтоох 71, бэлгийн холбогдолтой 3, нас тогтоох 1, цогцост үзлэг хийх 9, криминалистикийн 15, задлан шинжилгээ 9 химийн шинжилгээ 6 хийж, шинжилгээгээр нотолсон хэрэг 3, шинжээчийн дүгнэлтийг хугацаанд нь гарган ажилласан.

**Дөрөв: Боловсрол, соёл, эрүүл мэнд,
нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд:**

Эрүүл мэндийн чиглэлээр:

Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ:

Аймгийн хэмжээнд томуунаас урьдчилан сэргийлэх “Дархлаажуулалтын 10 хоног”-ийг амжилттай зохион байгуулж, 1360 хүн тун вакцинаар эрсдэлт бүлгийн хүн ам болон эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг дархлаажуулж, 99,7%-тай хамруулсан.

ХӨСҮТ, сумын эмч нарын холбооноос хамтран зохион байгуулсан цахим сургалтад хамрагдаж, сумдад сүрьеэгийн идэвхтэй үзлэг хийх тухай гэрээг аймгийн Засаг даргаар батлуулан холбогдох байгууллагад хүргүүлсэн.

Намрын ээлжит цэрэг татлагын үйл ажиллагаанд ажиллаж, 260 иргэнийг эмчийн үзлэгт хамруулж, БЖИ тодорхойлж, биеийн халуун үзэж, гарыг халдваргүйжүүлсэн.

Орон нутгийн сонгуулийн үеэр аймгийн хэмжээний санал авах байруудад холбогдох дүрэм журмыг баримтлан халдвар хамгааллын чиглэлээр хяналт тавьж ажилласан.

Эмнэлгийн тусламж үйлчилгээ үйлчилгээ:

Өндөржүүлсэн бэлэн байдлын үеийн долоо хоног тутмын ажлын тайланг Эрүүл мэндийн байгууллагуудаас авч нэгтгэн, ЭМЯ-ны эмнэлгийн тусламжийн хэлтэст хүргүүлсэн. Мөн 14 хоног тутмын өвөлжилтийн мэдээг авч нэгтгэн, холбогдох байгууллагад хүргүүлсэн.

Хутаг-Өндөр суманд үйл ажиллагаа явуулж буй 4 Эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагаанд салбарын дотоодын хяналт хийж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажилласан.

ЭХЭМҮТ-ийн Тандалт судалгааны албанаас зохион байгуулсан эх, хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээний чиглэлийн 2 удаагийн цахим сургалтад холбогдох эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамруулж оролцсон.

“Эерэг хандлага-эмчилгээний эхлэл” аяны хэрэгжилтийн тайланд явцын хяналт хийсэн.

Боловсролын чиглэлээр:

“Тогтвортой хөгжлийн боловсрол-2” төслийн хүрээнд “Тогтвортой хөгжилд суралцахуй”, “Төсөл бичих дадлага ажил”, “Агентлагийн уялдаа холбоо” лекц, дадлага ажлыг бэлтгэлээ. “Эрдмийн өргөө цогцолбор” сургууль, Хялганат, Хишиг-Өндөр, Могод сумдын “Тогтвортой хөгжлийн бодлого-2” хэрэгжүүлж буй сургуулиудад тус бүр нэг өдрийн сургалтыг зохион байгуулсан.

Ерөнхий боловсролын 1-р сургууль, 6-р цэцэрлэг дээр хяналт үнэлгээ, зөвлөн туслах ажлыг зохион байгууллаа. “Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийж үнэлгээ өгөх шалгуур үзүүлэлтүүд”-ээр хяналт үнэлгээ хийх сургуулийн хөтөлбөрийн менежментийн хэрэгжилттэй танилцах зөвлөн туслах зорилгоор Булган сумын 1 дүгээр сургууль дээр 2020 оны 10 дугаар сарын 12-14-ны өдөр БСУГ-ын дарга Э.Түвшинмөнхөөр ахлуулсан ажлын хэсэг ажиллав. Хяналт шинжилгээ, зөвлөн туслах ажлын хүрээнд 55 багшийн хичээлд сууж 60-н багшид мэргэжил арга зүйн зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, 52 багш, 120 сурагч, 350 эцэг эхчүүдээс сэтгэл ханамжийн судалгаа авч ажилласан. Хяналт үнэлгээгээр тус сургуулийн үйл ажиллагаа 56.1 хувьтай дүгнэгдсэн.

Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангийн сурагч, багшийн ЭЕШ-ийн бэлтгэлд дэмжлэг үзүүлэх, судлагдахуун бүрийн агуулга, арга зүйг оношлох, сургалтын чанарыг сайжруулах зорилго бүхий сорил шалгалтыг 2020 оны 10 дугаар сарын 21нд зохион байгуулсан. Сорил шалгалтад 10 хичээлээр давхардсан тоогоор 15 сургуулийн 1713 сурагч хамрагдсан ба 116532 оноо авхаас 43615.3 оноо авч 37.43 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн ба сорил өгсөн нийт сурагчдын 44,6 хувь нь аймгийн төв, 55.4 хувь нь сумын сургуулийн сурагч хамрагдсан.

Булган аймгийн төвийн цэцэрлэгийн багш нарт 2020.10.22-23-ны өдрүүдэд **“Хүүхэд бүрийг хөгжүүлэх сургалтын арга зүй”** сэдэвт сургалт, семинарыг Япон улсын Жайка төслийн сургагч багш Т.Кимико зохион байгууллаа. Сургалтад төвийн бүсийн 6 цэцэрлэгийн 40 багш, арга зүйч, 34 туслах багш, хүүхэд харах үйлчилгээний 3, нийт 77 хүн хамрагдсан.

Хишиг-Өндөр сумын бага ангийн 2 багш, Орхон аймгийн 14-р сургуулийн бага ангийн 2 багштай “Багш солилцоо” зохион байгуулсан.

Монгол хэл, бичгийн багш нарын мэдлэг боловсролыг дээшлүүлэх сургалтыг 2020 оны 10 дугаар сарын 3, 4нд зохион байгуулж, 60 багш хамрагдсан.

Аймгийн төв номын сан, насан туршийн боловсролын төв болон өөрийн газрынхаа номын санд 2 500 000 гаруй төгрөгийн үнэ бүхий номоор фонд баяжилт хийсэн.

Хөвсгөл аймагт 10-р сарын 29-30-ны өдрүүдэд болж буй Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх” төслийн хүрээнд нийлүүлэгдсэн багаж, тоног төхөөрөмжийг хичээл, сургалтын үйл ажиллагаанд ашиглах сургалтад физик, хими, дизайн технологийн багш, мэргэжилтнүүд хамрагдсан.

Биеийн тамир, спортын чиглэлээр:

Үндэсний бөхийн өсвөр үеийн 2020 оны Улсын аварга шалгаруулах шигшээ барилдаан Анхдагчдын өлгий Булган аймагт энэ сарын 30, 31-ны өдрүүдэд явагдаж дүнгээ гаргалаа. Барилдаанд 20 аймаг, 9 дүүргийн нийт 84 бөх 16, 17, 18 насны ангилалд уран мэхийг уралдуулан барилдлаа.

Багийн дүнгээр

1-р байр Г. Нямдорж дасгалжуулагчтай ХУД

2-р байр С.Лхагвасүрэн дасгалжуулагчтай Булган аймаг

3-р байр Б.Бадарч дасгалжуулагчтай Увс аймаг тус тус шалгарлаа.

МҮОХ-ны ерөнхийлөгч Н.Түвшинбаяр өнөөдөр Булган аймагт зочилж “Москва” олимпийн зөвлөлийн үйл ажиллагаатай танилцаж, удирдлагуудтай уулзан олимпийн зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар санал солилцов. Уулзалтаар “Москва” олимпийн зөвлөлийн дарга Д.Эрдэнэбилэг үйл ажиллагаагаа танилцуулан, цаашид удирдах зөвлөлийн гишүүдийг нэмэгдүүлэх, сургуулиудын олимпийн танхимуудыг олноор бий болгохыг дурдаад, Спорт – Олимпизмийг өргөн хэмжээнд сурталчлан, хүүхэд залуусын эрүүл мэндийг дээшлүүлэхэд Биеийн тамир спортын газар – Боловсрол соёлын газар болон олон нийтийн байгууллагуудтай нягт хамтран ажиллах хүсэлтэй байгаагаа хэлэв.

Хэвтээ шахалтын хэрэглэлтэй, хэрэглэлгүй Улсын аварга шалгаруулах тэмцээнд Булган аймгаас 9-н тамирчин оролцлоо. УАШТ-ээс алтан медаль 2 мөнгөн медаль 3, хүрэл медаль 2 хүртэж, ОУХМ О.Мөнхбат хэвтээ шахалтын хэрэглэлгүй төрөлд 231 кг өргөж Монгол улсын рекордыг шинэчлэн тогтоолоо.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын чиглэлээр:

Хүүхэд, залуучуудын хөгжлийн ордонд 8 төрлийн дугуйлан клубд хүүхдийг ажлын 5 өдрийн хуваарийн дагуу хамруулж ажиллалаа.

Үүнд:

- Хүүхдийн оролцооны байгууллагын нийт 12 хүүхэд ажлын 3 өдрөөр, давхардсан тоогоор 144 хүүхэд.
- Өсвөрийн сэтгэл зүйч клубд 9 хүүхэд давхардсан тоогоор 36 хүүхэд.
- Өсвөрийн сэтгүүлч клубд 5 хүүхэд ажлын 3 өдрөөр, давхардсан тоогоор 60 хүүхэд.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өдөр өнжүүлэх төвд ажлын 5 өдрөөр 9 хүүхэд, давхардсан тоогоор 180 хүүхэд.

- Соробан сампин, баруун тархи хөгжүүлэх сургалтад 14 хүүхэд ажлын 4 өдрөөр хичээллэж, давхардсан тоогоор 224 хүүхэд.
- Теннисний секц 26 хүүхэд ажлын 4 өдрөөр хичээллэж, давхардсан тоогоор 416 хүүхэд.
- Хичээлээс гадуурх өдөр өнжүүлэх төвд 5 хүүхэд ажлын 5 өдрөөр, давхардсан тоогоор 100 хүүхэд.
- Гар зургийн дугуйлан 12 хүүхэд ажлын 3 өдрөөр, давхардсан тоогоор 144 хүүхэд тус тус хамрагдаж, нийт 1304 хүүхэд хөгжлийн ордны үйлчилгээнд хамрагдсан байна.

Дээрх хүүхэд хөгжлийн арга хэмжээнүүдийг 2020 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс үйл ажиллагааны хуваарийн дагуу төлөвлөлтөө хийж, 2020 оны 09 дүгээр сарын 21-ний өдрөөс 10 сарын 26 хүртэл үйл ажиллагаагаа эцсийн байдлаар жигдрэн ажиллаж байна.

Хүүхдийн оролцооны чиглэлээр:

Аймгийн хүүхдийн парламентын хүүхдүүдийн санаачилгаар “Өв соёлоо түгээн дэлгэрүүлцгээе” уриатай сарын аян зарлагдаж үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан аймгийн БСУГ-тай хамтран үндсэн 4 ажлыг өрнүүлэхээр бэлтгэл ханган ажиллаж, үндсэн 2 ажлыг гүйцэтгэж, 3 дахь үйл ажиллагаа болох “Илтгэл мэтгэлцээн” -ий тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах шагналын сангийн төсөв үүсгэх зорилго бүхий “Кино 7 хоног”-ийг 2020.10.19-22 хүртэлх хугацаанд ГБХЗХГ-ын кино театрт амжилттай зохион байгуулж, Tran to busan: Peninsula, Sadako, Countown, Invisible зэрэг 4 киног нийт 542 хүүхдийг хамруулж, 542,000 төгрөг цугласан байна.

“УРГАА МЭДВЭЛ – УЛСАА МЭДНЭ” угийн бичиг хөтлөх уралдааныг 16 сум 1 тосгоны 9-р ангийн нийт 33 бүлгийн 752 хүүхдийн дунд зохион байгуулах удирдамжийг боловсруулан ЕБС-ийн нийгмийн ажилтан, анги удирдсан багш нарт хүргэж ажиллаа.

Хүүхэд өсвөр үеийнхний нийгмийн амьдралд оролцох эрхийг хангах, тэдний дуу хоолойг сонсож, шинэ санал санаачлагыг дэмжин үе тэнгийнхэнд хүргэж, эерэг нөлөөлөл бий болгох хүүхдийн оролцооны бүлгийн цар хүрээг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд ГБХЗХГ-ын дэргэдэх “Өсвөрийн сэтгүүлч” клубтэй болж ХӨУБ-ын шинэ элсэлтээ авлаа.

Хичээлийн шинэ жил эхэлсэнтэй холбогдуулан ХӨУБ-ын нэгдсэн судалгаа гаргаж ажиллалаа.

Хөдөлмөр халамж үйлчилгээний чиглэлээр:

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр:

Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд 2020 оны 10-р сарын байдлаар 1295 иргэн ажил хайгчаар бүртгэлтэй байгаагаас шинээр 189 иргэн идэвхтэй ажил хайгчаар бүртгүүлсэн байна. Ажилгүйдлийн тэтгэмжийн тодорхойлолтыг 39 иргэнд гарган Нийгмийн даатгалын хэлтэст хүргүүлэв.

Ажил олгогч 21 байгууллагаас 149 ажлын байрны захиалга авч, Орон нутгийн телевиз болон зарын цэгүүдээр байршуулан зар сурталчилгааг явуулж, 139 иргэнийг улирлын болон түр ажлын байранд зуучлан ажиллалаа.

Шинэ ажлын байр: Шинээр бий болж байгаа ажлын байранд 109 иргэн орж ажилласнаас байнгын ажлын байранд 22 иргэн, улирлын ажлын байранд 20 иргэн, түр ажлын байранд 67 иргэн тус тус ажлын байранд зуучлагдан ажиллаж байна.

Ажилд зуучлагдсан иргэн: Ажил олгогч иргэн, аж ахуйн нэгж байгууллагын сул чөлөөтэй ажлын байранд 139 иргэн ажлын байранд зуучлагдснаас байнгын ажлын байранд 97 иргэн, улирлын ажлын байранд 14 иргэн, түр ажлын байранд 28 иргэн тус тус зуучлагдан ажиллаж байна.

Байгууллагын хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийн талаарх мэдээллийг шилэн дансны мэдээлэлд оруулж баталгаажуулав.

Авлигатай тэмцэх газрын 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01/1004 тоот зөвлөмжийн хэрэгжилтийг гарган Аймгийн ЗДТГ-ын Хууль эрхзүйн хэлтэст цахимаар хүргүүлсэн.

Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээний хүрээнд:

Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох ганцаарчилсан зөвлөгөөг 61 иргэнд өгч, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн санд бүртгэлжүүлэв. Өссөн дүнгээр ганцаарчилсан зөвлөгөөг 401 иргэнд үзүүлсэн байна. Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох бүлгийн сургалтыг ажил идэвхтэй хайж буй 25 иргэнд зохион байгуулан, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн санд бүртгэлээ. Мөн Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний загвар төвөөр дамжуулан, ажил идэвхтэй хайж буй 5 залууст Модуль-1,2 хичээлийг явуулж, загвар төвийн ажилтантай хамтран ажиллав. Сарын мэдээг сар бүрийн 25-ны өдрийн дотор гарган ХХҮЕГ-т хүргүүлж байна.

Хөдөлмөрийн харилцааны ажлын хүрээнд:

Ургац хураалтын үед ажилласан иргэдийн мэдээллийг гарган ХХҮЕГ-т хүргүүлэв. Мөн хөдөлмөрийн гэрээ байгуулахтай холбоотой асуудлаар 3 иргэнд зөвлөгөө өгөв.

Хөдөлмөрийн бүтээмжийн асуудлаар “Сайхан Монгол” ТВ-тэй хамтран мэдээлэл хийхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлын хүрээнд:

Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг иргэдийг ургац хураалтын үед ажиллахад зориулан 2 дахь удаагийн ХАБЭА-н зөвлөмж гарган, нийт сумдад зөвлөмжийг хүргүүлэв.

Аймгийн Автотээврийн газрын хамт олонд “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй”-н талаар сургалт зохион байгуулж, 11 ажилтныг хамруулав.

Ажиллах хүч нийлүүлэх гэрээ байгуулах ажлын хүрээнд:

Нийт 34 төрлийн тендерийн ажилд 87 компанитай ажиллах хүч нийлүүлэх гэрээ байгуулан ажиллалаа.

Ажил хайгчийн хөдөлмөр эрхлэх чадварыг үнэлэх үйлчилгээнд 19 иргэн хамрагдсан. /үүнд 15-24 насны 9, 25-34 насны 10 хүн/

“Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний загвар төв”-д ажил идэвхтэй хайж байгаа залуучуудад зориулсан залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн үе шаттай модуль сургалтыг зохион байгуулж, 2 эмэгтэйд ажил хайгчийн хувийн төлөвлөгөө боловсрууллаа.

ХЭДС-ийн сарын мэдээг гаргаж ХХҮЕГ-т тухай бүр хүргүүлэн, шилэн дансанд тухай бүр мэдээллийг байршуулж байна.

Булган аймгийн Төрийн аудитын газраас 2020 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсарын аудит хийх болсонтой холбогдуулан 2020 оны ХЭДС-ийн хагас жилийн тайлан болон холбогдох баримтыг хуваарийн дагуу хугацаанд нь хүлээлгэж өгсөн.

ХЭДС-ийн хөтөлбөрүүдийн авлагын насжилтын мэдээ, Аудитын 2016-2019 онуудын акт, албан шаардлага, зөвлөмжийн хариуг он тус бүрээр гаргаж, төсвийн хэтрэлт хэмнэлтийн судалгааг гаргаж ХХҮЕГ-т хүргүүлсэн.

Нийгмийн халамжийн чиглэлээр:

Халамжийн сангаас 2020 оны 10-р сард 5446 иргэнд 638,4 сая төгрөгийн тэтгэвэр тэтгэмж, хөнгөлөлт олгогдсон.

“ehalamj.mn” системд данс холболт болон хүсэлт хүлээн авах баталгаажуулалтын ажлыг тухай бүр хийж, сарын аяны хугацаанд ХААН болон Төрийн банкт байнга хамтран ажилласны үр дүнд тус 6 үйлчилгээнд хамрагдаж буй үйлчилгээ авагч иргэдийн дансыг **100%** холбож дуусгалаа.

Үйлчилгээ	Нийт үйлчилгээ авагчдын тоо	Баталгаажсан	Дансанд холбосон
Цалинтай ээж	2604	2604	2602
Алдарт эхийн одон	5587	5587	5582
Жирэмсэн эхийн тэтгэмж	507	507	507
Өрх толгойлсон эцэг, эхийн тэтгэмж	87	87	87
Насны хишиг	3160	3160	3160
Нийт дүн	11945	11945	11938

“ehalamj.mn” системтэй холбоотой мэдээллийг тухай бүр иргэдэд хүргэн үйлчилж байгаа ба ХХҮГ-ын 77311220, 70342092, 70342099 дугаарын утаснууд байнга нээлттэй ажиллаж иргэдийн асуултад хариулан зөвлөгөө мэдээлэл өгч байна. Сарын аяны хүрээнд цахимаар нийт 741 иргэн хүсэлт гарган хүсэлтийг цаг хугацаанд нь шийдвэрлэлээ.

Халамжийн сангаас тэтгэвэр, тэтгэмжийн үйлчилгээнд 18010 иргэнийг хамруулж, дараах үйлчилгээнүүдийг үзүүллээ. Үүнд:

- Нийгмийн халамжийн тэтгэвэр 1171 хүнд 2.170,8 сая төгрөг
- Нийгмийн халамжийн тэтгэмж 1628 хүнд 1.123,7 сая төгрөг
- Жирэмсэн хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмж 241 хүнд 16,9 сая төгрөг
- Цалинтай ээжийн хөтөлбөрийн хүрээнд 681 эхэд 128,9 сая төгрөг
- Өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж 111 хүнд 84,0 сая төгрөг
- Ахмад настанд үзүүлсэн хөнгөлөлт тусламж 1626 хүнд 194,7 сая төгрөг
- ХБИ-д үзүүлсэн хөнгөлөлт тусламж 292 хүнд 46,5 сая төгрөг

- АЦА настанд үзүүлсэн хөнгөлөлт тусламж 29 хүнд 41,1 сая төгрөг
- Алдарт эхийн 1,2-р одонтой эхчүүдийн мөнгөн тусламж 5509 хүнд 704,8 сая төгрөг
- 65-аас дээш настай ахмадуудад насны хишиг олголт 3509 хүнд 524,7 сая төгрөг
- Амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж 1492 хүн 586,3 сая төгрөг
- Ихэр хүүхдийн тэтгэмж 7 хүнд 14,0 сая төгрөг, нийт 6.315,2 сая төгрөг олгосон байна.

Орон нутгийн халамжийн сангаас 2020 онд 79,2 сая төгрөгийн санхүүжилт авахаас бүрэн орж ирсэн бөгөөд дараах үйлчилгээнүүдийг үзүүлсэн байна. Үүнд:

- 18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны 6 иргэнд 7,2 сая төгрөг
- Гэр оронгүй болсон өрх, гэр орон нь цаашид амьдрах боломжгүй болсон 4 өрх-иргэнд 4,8 сая төгрөг
- Хорих газраас суллагдсан гэр оронгүй, нийгмийн халамжийн дэмжлэг тусалцаа зайлшгүй шаардлагатай 2 иргэнд 2,4 сая төгрөг, нийт 14,4 сая төгрөгийн олголтыг тус тус хийсэн байна.

Булган сумын хөдөлгөөний бэрхшээлтэй /саажилттай/ 4 хүүхдийг Канад сангийн Хөдөлгөөний засалч эмчид үзүүлж зөвлөгөө өгсөн. Нэгдсэн эмнэлгийн Уламжлалын тасгийн хөдөлгөөн заслын кабинетад 12 ХБХ-ийг хамруулан хөдөлгөөн заслын эмчилгээнд хамрууллаа. Асаргаанд байгаа хүүхдүүдийг нөхөн сэргээх үйлчилгээг тухай бүрт нь хамруулсан байна.

Олон улсын Ахмадын баярыг тохиолдуулан Булган сумын асаргаанд байдаг 50 ахмад настны гэрээр зочилж, Булган сумын харьяалалгүй 400 ахмадад гарын бэлэг тараалаа.

Хутаг-Өндөр суманд үйл ажиллагаа явуулж байгаа Махны үйлдвэрт Булган сумын зорилтот бүлгийн иргэдээс 2 иргэнийг зуучилж ажилд орууллаа.

Тав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд:

Мал аж ахуйн талаар :

Засгийн газрын “Хөдөө аж ахуйн салбарын 2020-2021 оны өвөлжилтийн бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай” 19 дүгээр тогтоол, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн “Мал аж ахуйн өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах нэгдсэн төлөвлөгөө батлах тухай” 37 дугаар тогтоол, аймгийн онцгой комиссын 01 тоот албан даалгавруудын хэрэгжилтийг хангаж ажиллаж зорилгоор сумдад хадлан, тэжээл бэлтгэлийн ажлыг чанартай, шуурхай зохион байгуулах, малдаа хүрэлцэхүйц хэмжээний өвс, тэжээлийг бэлтгэж нөөцлөх, худаг уст цэгийн эзэмшилт, ашиглалт, хашаа хорооны хангамжийг сайжруулах, эр сувай малыг зах зээлд борлуулах, зам даваа хаагдаж болзошгүй газарт өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэх, малчдын хувийн бэлтгэлийг сайтар хангуулахад ихээхэн анхаарч өдөр тутам үүрэг чиглэл өгч ажиллаж байна.

2020-2021 онд 16 сум 1 тосгон, 75 багийн 8.8 мянган малчин өрхөд урьдчилсан байдлаар 3.5 сая толгой мал өвөлжихөөр зохион байгуулж байна.

Аймгийн хэмжээнд малчдын хүчээр 111.2 мянган тн байгалийн хадлан, 1.6 мянган тн ногоон тэжээл, 7.6 мянган тн үйлдвэрийн тэжээл, 1.6 мянган тн гар

тэжээл, 13.1 мянган тн давс хужир, шүү бэлтгэхээс 90.3 мянган тн байгалийн хадлан, 6,3 мянган тн ногоон тэжээл, 1.9 мянган үйлдвэрийн тэжээл, 2.7 мянган тн гар тэжээл, 414 тн дарш ногооны хаягдал, 9.5 мянган тн давс, хужир шүү бэлтгэж, нийт өвс, тэжээлийн 69.6 хувийг бэлтгээд байна.

Аймаг, сумын аюулгүйн нөөцөд аймаг 175 тн өвс, сумд 1.2 мянган тн өвс, 205,5 тн тэжээл бэлтгэсэн бөгөөд өвсний 54.7 %, тэжээлийн 11.5%-ийг бэлтгэж, аймгийн дунджаар 33.1% -ийг бэлтгэсэн мэдээг сумдаас авч нэгтгээд байна.

Өнгөрсөн зун зуншлага оройтож болсонтой холбоотой хадлангийн ургац тааруу байна. Мөн хадлан бэлтгэлийн үед цаг агаар сэрүүсч, цас, бороо орсонтой холбоотой удааширсан.

Малчдын түвшинд бэлтгэх болон аймаг, сумын аюулгүйн нөөцөд бэлтгэх өвс тэжээлийг цаг алдалгүй шуурхай татан авах ажлыг орон нутгийн түвшинд зохион байгуулахгүй бол нөхцөл байдал хүндрэх төлөвтэй байна.

Өөр аймгийн нутагт 38 малчин өрхийн 26.7 мянга, өөрийн аймгийн бусад сумдын нутагт 292 малчин өрхийн 34.1 мянга, хилийн зурвас бүс нутагт 10 малчин өрхийн 1.7 мянга, улсын тусгай хамгаалалттай бүс нутагт 120 малчин өрхийн 69.7 мянга, тусгай хэрэгцээний отрын бүс нутагт 56 малчин өрхийн 38.0 мянга, нийт 516 малчин өрхийн 170.3 мянган мал отроор өвөлжих судалгааг гаргаад байна.

Баяннуур, Гурванбулаг, Рашаант, Орхон, Дашинчилэн сумдад Өвөрхангай аймгийн 12 сумын 23 малчин өрхийн 25.6 мянган толгой, Баянхонгор аймгийн 5 сумын 5 малчин өрхийн 7.5 мянган толгой, Архангай аймгийн 2 сумын 2 малчин өрхийн 2.6 мянган толгой, Төв аймгийн 1 сумын 3 малчин өрхийн 2.1 мянган толгой, Завхан аймгийн 1 сумын 1 өрхийн 27 толгой, Дундговь аймгийн 1 сумын 1 малчин өрхийн 16 толгой мал, нийт 6 аймгийн 22 сумын 39 малчин өрхийн 37.1 мянган толгой мал отроор өвөлжихөөр ирсэн судалгааг сумдаас аваад байна.

Хүнс, хөдөө аж ахуйн сайдын “Заавар шинэчлэн батлах тухай” 2016 оны А/71 дугаар тушаалын хавсралт “Мал өвөлжилтийн бэлтгэл хангах, шалгах, дүгнэх заавар”-ын дагуу сумдын мал өвөлжилтийн бэлтгэл ажлыг урьдчилсан байдлаар дүгнэж үзэхэд 72.5%-иар хангаад байна. Малчдын өвс, тэжээл бэлтгэл 69.6%, аймгийн аюулгүйн нөөцийн бэлтгэл 11.4%, сумын аюулгүйн нөөцийн бэлтгэл 54.7%, худгийн бэлэн байдал 91.5%, малын усан хангамж 93,1%, малчин өрхийн хашаа, бууцны хангамж 97.1%, малчин өрхийн өвөлжилтийн бэлтгэл 90.2% - тай байна.

Дашинчилэн суманд “Чилэн” аймаг дундын отрын бүсийн орон тооны бус зөвлөлийн хуралд ХХААГазрын дарга Ч.Амгалан, МАА-н албаны мэргэжилтэн Ц.Бямбацогт нар оролцсон.

Дашинчилэн, Баяннуур, Хишиг-Өндөр, Бүрэгхангай сумдад орон нутгийн төсвийн хөрөнгөөр гаргасан ажилд гүйцэтгэлийн хяналт хийж, ашиглалтад хүлээж авлаа.

Аймгийн хэмжээнд 3955 малчин өрхийн 1030,4 мянган тн ноосны падааныг үндэсний үйлдвэрүүдтэй тулгаж, баталгаажууллаа.

Хүнс, газар тариалангийн талаар:

Аймгийн хэмжээнд 10 сарын 23-ны өдрийн мэдээгээр бараа, бүтээгдэхүүний нөөц тогтвортой байна. Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүн мах, махан

бүтээгдэхүүн 104,45 тн – 17 хоног, гурил 75,08тн – 15 хоног, төрөл бүрийн будаа 32,31тн – 13 хоног, элсэн чихэр 14,13тн – 8,5 хоног, ургамлын тос 9,23тн – 8 хоног, өндөг 71800 ширхэг буюу 3,59тн – 3,5 хоног, давс 10,97 тн – 43 хоногийн гурилан бүтээгдэхүүн 73,22тн – 8 хоног, төмс 2497,22тн – 411,5 хоног, хүнсний ногоо 327,06тн – 24,9 хоног, хуурай сүү 15,74тн – 2 хоногийн нөөцтэй байна. Өнгөрсөн сар цаг үеийн нөхцөл байдлаас хамаарч ургац хураалт дууссантай холбоотой агуулахын нөөц нэмэгдэж байгаа бол сэрүүн орж байгаатай холбоотой өндөгний нийлүүлэлт буурсан байна.

Ихэнх сумын хүнсний нөөц, хангамж хэвийн татан авалт хэвийн байгаа. Иргэдийн худалдан авалт тогтвортой байна. Улаанбаатар, Орхон аймгийн хүнсний үйлдвэрийн зарим бүтээгдэхүүний үнэ нэмэгдсэнээр гурил, импортын цагаан будаа, элсэн чихрийн үнэ нэмэгдсэн байна.

Мал эмнэлгийн талаар:

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ:

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэхээр нийт 1,255 мянган толгой мал хамрагдахаас 1,009 мянган толгой мал хамрагдаж 80,4 хувийн гүйцэтгэлтэй байна.

Бруцеллёзын вакцинжуулалтын арга хэмжээнд нийт 845,6 мянган толгой мал хамрагдахаас 747,2 мянган мал хамрагдаж 88,4 хувийн гүйцэтгэлтэй.

Шимэгчтэх өвчнөөс сэргийлэх арга хэмжээ:

Аймгийн Засаг даргын энэ оны 05 дугаар сарын 05-ны өдрийн А/217 дугаар захирамжийн дагуу хийгдэж байгаа мал угаалгын арга хэмжээнд 44,0 мянган үхэр, 1281,5 мянган хонь, 734,2 мянган ямаа нийт 2059,7 мянган толгой мал хамрагдаж 61,1 хувийн гүйцэтгэлтэй угаалгын арга хэмжээ дууссан.

Хяналт, шинжилгээ үнэлгээ:

Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын баталсан 2020 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн 13 дугаар удирдамжын хүрээнд Хутаг-Өндөр суманд байрлалтай “Булган мах маркет”, “Занадура Разобак” мал төхөөрөх үйлдвэр, цехийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийлээ.

УМЭАЦТЛ-ийн тасгийн дарга, лабораторийн эрхлэгч, шинжлэгч эмч, сумын мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч нартай хамтран Тэшиг, Хутаг-Өндөр суманд бруцеллёз өвчнөөс сэргийлэх вакцинжуулалтын дараах мониторинг хийсэн.

Энэ онд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд био комбинатаас нийлүүлсэн вакцинд хяналт хийж улсын байцаагчийн дүгнэлт гаргаж МЭЕГ-т хүргүүлсэн.

Мал эмнэлгийн лабораторийн шинжилгээний талаар:

Ийлдэс судлалын шинжилгээнд:

Орон нутагт хийгдсэн бруцеллёз, ям сүрьеэ өвчний шинжилгээ хийгдсэн тайланг нэгтгэн авч дүнгээ гаргаж байна. Аймгийн хэмжээнд нийт бух-875, хуц-8869, ухна-4792 нийт 14536 хээлтүүлэгч мал хамрагдаж, Баян-Агт, Бугат, Бүрэгхангай, Гурванбулаг, Могод, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр, Рашаант, Тэшиг, Орхон, Сайхан сумдад нийт 68 малд бруцеллёз өвчин илэрч зааврын дагуу арга хэмжээг

хэрэгжүүлж байна. Төлөвлөгөөний дагуу ям, сүрьеэ өвчний харшил сорилын шинжилгээний гүйцэтгэлийг хангуулахаар ажиллаж байна.

Нян судлалын шинжилгээнд:

3 дээж ирж Могод, Хутаг-Өндөр суманд хонинд цусан халдварт өвчин тус оношлогдсон.

Ариун цэврийн үзлэг шинжилгээнд:

Булган суманд мал аж ахуйн бүтээгдэхүүн борлуулдаг аж ахуй нэгж байгууллага, сургууль, цэцэрлэгт нийлүүлэгдэж байгаа мах, сүү, мөн нөөцийн махны дээжүүдэд ариун цэврийн үзлэг шинжилгээ хийгдэж нийт 21 дээж хамрагдсан. Үүнд: Махны 16 дээж, сүү, сүүн бүтээгдэхүүний 5 дээж ирж шинжилгээнд хамрагдаж хариуг холбогдох газар хүргүүлж ажилласан.

**Зургаа: Байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ,
дэд бүтцийн салбарын чиглэлээр:**

Байгаль, орчны чиглэлээр:

Ойн хүрээнд:

Булган аймгийн Сум дундын ойн анги 2017-2018 онд ойн хортонд нэрвэгдсэн ойд талбай тусгаарлалт хийж, “Билгүүн дэлгэрэх” ХХК-тай цэвэрлэгээний огтлолын гэрээ байгуулж, айл өрх иргэдийн малын хашаа барих хэрэглээнд мод бэлтгэх ажлыг эхлүүлээд байна.

Сэлэнгэ сумын 2-р тасгийн байгаль хамгаалагч П.Оюунчимэг Харцайн постод 3 хоног ажиллаж, самрын дагалтын зөвшөөрөл олгож сумын төрийн санд 12 сая 800000 төгрөгийг төвлөрүүллээ.

Орхон сумын 4-р багийн байгаль хамгаалагч С.Оюунбадрах иргэдэд 30 м.куб түлээний эрхийн бичиг олгож, сумын төрийн санд 120 000 төгрөгийн орлого оруулав.

Аймгийн Засаг даргын томилсон ажлын хэсэг Сэлэнгэ сумын 200 га, Хангал сумын 180 га, Бугат сумын 50 га газрын ойжуулалт, Рашаант суманд хийсэн 2 га ойн зурвасын ажлыг хүлээн авлаа. Сэлэнгэ сумын Тариахтайн даваанд Дархан цаазат газрын хийсэн цэвэрлэгээний ажлын талбайг хүлээн авлаа.

Булган аймгийн Хангал сумын 2-р багийн нутагт үйл ажиллагаа явуулж байгаа “Өлзийт Хангал” ХХК-ийн “Чулуутын ам” төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг баталж хүргүүлэв.

“Ихэр Согоот” ХХК нь Сэлэнгэ суманд 100 м3 мод бэлтгэх, Орхон сумын Нумтад 20 га-д талбайд мод бэлтгэхээр тусгаарлалт хийлгэлээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 63 тоот зарлигийн дагуу "Соёл амралтын цэцэрлэгт хүрээлэн", "Бурхан багшийн энергийн цэцэрлэгт хүрээлэн", "Ногоо паспорт- Ногоон төгөл" бичил цэцэрлэгт хүрээлэнд 46 байгууллагын 510 хүн 7 төрлийн 489 мод бут тарилаа.

Усны хүрээнд:

Уул уурхайн зориулалтаар ус ашиглагч 1 иргэн, 7 нөхөрлөл, 4 аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг аймгийн Засаг даргын тамгын газар, Мэргэжлийн хяналтын газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Цагдаагийн

газартай хамтран шалгаж, Усны тухай хууль, тогтоомжийг сурталчлан таниулж, зөвлөмж өглөө.

Уул уурхайн зориулалтаар ус ашиглагч 10 аж ахуйн нэгжид усны нөөц ашигласны төлбөрийг гэрээнд заасны дагуу хугацаанд нь төвлөрүүлэх талаар зөвлөмж өглөө. 2020 оны 10 сарын 16 ны байдлаар аймгийн төсөвт 8,9 тэрбум төгрөг төвлөрүүлээд байна.

Дашинчилэн сумын 4 дүгээр багийн нутагт үйл ажиллагаа явуулж байгаа “Соргог төгөл” ХХК-ний чацарганын усалгааны нормыг тооцож дүгнэлт гаргалаа.

Нөхөн сэргээлт, тусгай хамгаалалттай газар нутаг,

БОНБЕУ-ний хүрээнд:

Могод сумын “Гадна усан хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний дагалдах барилга байгууламж”-ийн төсөлд байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийлээ.

Бүрэгхангай сумын Дэрст багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа “Монполимет” ХХК-ийн 2008-2019 оны нөхөн сэргээлтийн ажлыг дүгнэсэн баримт бичгийн хуулбар хувийг аймгийн Цагдаагийн газарт хүргүүлэв.

Баян-Агт сумын Хануй, Цагаан гол, Шаргын нуур, Бага нуур, Цэгээн нуур, Бөөргийн нуур, Дулаан хан уул, Сайхан сумын Хунтын рашаан, Могод сумын Хульжийн рашаан, Хутаг-Өндөр сумын Их булгийн рашаан, Орхон сумын Баян хаант уулыг орон нутгийн тусгай хамгаалалтад авах ажлыг зохион байгуулж сумын ИТХ-ын тогтоолоор хамгаалалтад авлаа.

Бүрэгхангай сумын нутаг дэвсгэрт уул уурхайн үйлдвэрлэл эрхлэгч 5 аж ахуйн нэгжид зөвлөмж өгч, усны нөөц ашигласны төлбөрийг гэрээнд заасны дагуу бүрэн төвлөрүүлэхийг мэдэгдлээ.

Хог хаягдлын хүрээнд:

Булган сумын ТҮА аймгийн төвийн 6 баг, нийтийн эзэмшлийн талбай, ААНБ-ын хогийг графикайн дагуу ачиж тээвэрлэж байна.

Сумдын хог хаягдлын төвлөрсөн цэгийн хог хаягдлыг дарж булах, хашаажуулах, шилжүүлэх ажлын гүйцэтгэлийг сумын Засаг даргын Тамгын газраас томилсон ажлын хэсэг хүлээн авлаа.

Баян-Агт сумын Засаг даргын Тамгын газар, ерөнхий боловсролын сургуулийн Эко клубын сурагчидтай хамтран дунд болон ахлах ангийн сурагчдад хог хаягдлын талаар сургалт хийж, сургуулийн орчин тойрны хог хаягдлыг цэвэрлэх ажлыг зохион байгууллаа.

Газрын харилцааны чиглэлээр:

Газар зохион байгуулалтын хүрээнд:

“Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем ажиллуулах” журам батлах тухай Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын даргын 2020 оны А/40 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах, 2020 оны төлөвлөгөөний хэрэгжилт, 2021 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулан гаргахтай холбогдуулан Газрын даргаар сургалтын хөтөлбөр боловсруулан батлуулж, 2020 оны 10 дугаар сарын 23-26-ны өдрүүдэд газрын даамлуудад сургалт зохион байгууллаа. Сургалтаар ГЗБГЗЗГ-ын газар зохион байгуулалтын хэлтсийн мэргэжилтэн, ГХБХБГ-ын мэргэжилтэн, Онцгой байдлын газраас мэдээлэл танилцуулга, заавар зөвлөмж чиглэл өгч ажиллаа.

“Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө” /Баян-Агт, Баяннуур, Бүрэгхангай, Гурванбулаг, Могод, Сайхан, Рашаант сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг/ боловсруулах зөвлөх үйлчилгээний тендер 2020 онд зарлагдаж, мэргэжлийн “Вектор мэл” ХХК шалгаран Сумын Засаг даргын 2020 оны А/375 дугаар захирамжаар гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгосон. Уг ажлын хүрээнд Баяннуур, Рашаант, Гурванбулаг сумын газар ашиглалтын судалгаа болон хээрийн хэмжилт судалгааны ажлыг гүйцэтгээд байна.

Газрын татвар төлбөр үнэлгээний хүрээнд:

Газрын дуудлага худалдааг газрын биржид мэдээлэн зохион байгуулж байгаатай холбоотой 2020 оны 10-р сарын 23-ны байдлаар өссөн дүнгээр тус цахим системд газар эзэмшүүлэх дуудлага худалдаагаар нийт 96 нэгж талбарын газар зарлагдсанаас танхимын хэлбэрээр 24 нэгж талбарт, цахим хэлбэрээр 72 нэгж талбарын газруудад дахин болон хэвийн байдлаар зарлагдан зохион байгуулагдлаа. Үүнээс 9 нэгж талбарын газар худалдаалагдаж төсөвт 141,8 сая төгрөгийг төвлөрүүлээд байна.

Аймгийн төвд инженерийн шугам сүлжээ бүхий төлөвлөгдсөн газарт 2020 оны А/363, А/371 дугаар захирамжийн дагуу үйлчилгээний зориулалтаар 0,07 га, ШТС-н зориулалтаар 0,07 га, авто машины гараашны зориулалтаар 4 нэгж талбар бүхий 0,0188 га, ХАА-н үйлдвэрлэлийн зориулалтаар 0,2082 га газруудыг газрын биржийн цахим системд зарлан 2020 оны 10-р сарын 12-нд зохион байгуулагдсан. Тус дуудлага худалдаанд : ХАА-н газарт иргэн Золжаргал 3323,0 мянган төгрөг, Авто гараашны зориулалтаар иргэн Х.Болдбаатар нь 2 нэгж талбарт ялалт байгуулан 4382,0 мян.төгрөг, 3882,0 мян.төгрөгөөр Т.Золжаргал 332,0 мян.төг, Д.Мөнхбат 3682,0 мян.төгрөгөөр үйлчилгээний зориулалтаар “Тусгалтын Өндөр” ХХК 4500,0 мян.төгрөгөөр, ШТС-ын зориулалтаар “ЧЭС” ХХК нь 50700,0 мян.төгрөгөөр тус тус ялалт байгууллаа. Тус дуудлага худалдаанд ялалт байгуулсан иргэд аж ахуйн нэгж байгууллагатай ялагчтай байгуулах гэрээг байгуулав.

Геодези зураг зүйн хүрээнд:

Бугат, Сайхан, Сэлэнгэ, Баяннуур, Бүрэгхангай, Могод, Рашаант сумдын газар зүйн нэрийн жагсаалт, шинэ болон өөрчлөгдсөн нэрийг хэлэлцүүлэн, шинэ болон өөрчлөгдсөн нэрийг дэмжих ИТХ-ын тогтоолыг нэгтгэн ГЗБГЗЗГ-т хүргүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Газрын кадастрын хэмжилтийг нийт 15 нэгж талбар, үл хөдлөх эд хөрөнгөнд хийж гүйцэтгэснээс 8 иргэн, хуулийн этгээд газар болон үл хөдлөх эд хөрөнгийн зураглалыг мэдээллийн санд оруулж ажилласан. Дээрхи үйл ажиллагаанаас 189 568 төгрөгийг төрийн сангийн 100040029002 дансанд төвлөрүүлсэн.

Барилга хот байгуулалтын чиглэлээр:

Булган аймагийн Булган сумын Ерөнхий боловсролын

12 жилийн 1-р бүрэн дунд сургуулийн биеийн тамирын талбай

Булган аймгийн Булган сумын Ерөнхий боловсролын 12 жилийн 1-р бүрэн дунд сургуулийн биеийн тамирын талбайн ажлын нь Орон нутгийн төсөв 99 139 512 төгрөгийн өртөгтэй бөгөөд Зураг төслийн автор “Виллкон” ХХК, гүйцэтгэгч Эрдэнэт аймгийн “Новый мираж” ХХК шалгаран гүйцэтгэж

байна. Биеийн тамирын талбайн ажлын ургамлын хөрсөн үеийг хуулж, хайргаар нягтруулж, Хөл бөмбөгийн талбай 40м x 18.8 м хэмжээтэй хиймэл зүлэгт талбай, 160м урт x 2м өргөн хэмжээтэй резинэн гүйлтийн замын бетон дэвсгэр үеийг 100 мм зузаантай хийж дууссан.

Хангал сумын спорт заал

Хангал сумын спорт заалны барилга нь Улсын болон орон нутгийн төсөв 438 895 112 төгрөгийн гэрээний дүнтэй бөгөөд Зураг төслийн автор: “Үндсэн төсөл” ХХК, Барилга угсралтын ажлын гүйцэтгэгчээр “Анэрд” ХХК шалгарсан. Барилга угсралтын ажил 2020 оны 05 сарын 30-нд эхэлсэн. 15м x 24м харьцаатай спорт заалны барилга угсралтын ажил дуусч байнгын ашиглатад авах Улсын комисс ажилласан.

Бугат сумын “Жаргалант” хүүхдийн зуслангийн захиргаа аж ахуй, хоолны барилга

Тус ажлын гүйцэтгэгчээр “Эрдэнэс эко үүр” ХХК шалгарч 920 002 045 төгрөгийн гэрээний дүн байгуулж 2020 оны 10 сарын 16-ны өдрөөс суурийн газар шорооны ажил эхэлж байна.

Булган сумын 3 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн барилга угсралтын ажил

Тус ажлын гүйцэтгэгчээр “Виртуалсофт” ХХК шалгарч 905 001 644 төгрөгийн гэрээний дүн байгуулж энэ оны 200,000,000 төгрөгийн суурийн ажил, 250кВ КТП байрлуулж хийж дууссан. Хавар барилга угсралтын ажил эхэлнэ.

Ус, цаг уур орчны шинжилгээний чиглэлээр:

10 сард цаг уурын ажиглагчийн мэргэжил олгох сургалтад 5 хүн хамруулж, орон нутгийн салбарт ажиллах боловсон хүчнийг сургах дадлагажуулах ажил хийгдэж байна.

2020 оны 10 сарын 5-аас 15-ны хооронд цөлжилтийг үнэлэх мониторингийн судалгааны ажил Могод, Хишиг-Өндөр, Гурванбулаг, Дашинчилэн, Рашаант, Баяннуур, Бүрэгхангай сумдад хийгдлээ.

2020 оны 10 дугаар сарын эхний 20 хоногийн агаарын бохирдлын хэмжээг MNS4585:2016 стандарттай харьцуулан үзэхэд өмнөх оны мөн үеэс бохирдолын хэмжээ буурсан үзүүлэлттэй байна.

2020 оны 10 дугаар сард 6 голоос усны бохирдлын дээж авч шинжилгээ хийн, MNS 4586:1998 стандарттай харьцуулахад м2бохирдолын хэмжээ хүлцэх агууламжаас давсан үзүүлэлт ажиглагдаагүй. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын “Хүнсний аюулгүй байдлын лавлагаа лаборатор”-иос ирсэн ундны усанд сульфат тодорхойлох гадаад чанарын хяналтын дээжинд шинжилгээ хийгдэж байна. Мөн Орхон сумын Халиун багт орших Чингэлийн голын усны дээжид шинжилгээ хийлгэх “Отгонтэнгэр оргил” ХХК-ний хүсэлтийн дагуу шинжилгээний ажил хийгдэж байна.

БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР